



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Жавхланта сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2025/142/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК

Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	Error! Bookmark not defined.
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..	12
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.5.3 Нэмэлт төсөв:	14
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2. Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ЖАВХЛАНТ СУМЫН 1 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
С.ОЮУНЧИМЭГ ТАНАА

2025-02-25 № СЭА-2025/142/СТА-НА-ТШЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж 12,804.6 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан

өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.9 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	114,840,218.60	133,398,528.18
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	93,363,868.60	79,486,349.24
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	93,363,868.60	79,486,349.24
3121	Төгрөг	93,363,868.60	79,486,349.24
31211	Төрийн сангийн харилцах	93,328,868.60	79,486,349.24
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	35,000.00	
33	АВЛАГА		
35	БАРАА МАТЕРИАЛ	21,476,350.00	53,912,178.94
354	Хангамжийн материал	21,476,350.00	53,912,178.94
3541	Бичиг хэргийн материал	59,500.00	59,500.00
3542	Аж ахуйн материал	6,685,200.00	41,014,499.94
3546	Хүнсний материал	3,116,890.00	1,223,419.00
3547	Бусад хангамжийн материал	11,614,760.00	11,614,760.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	368,323,579.07	574,616,268.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	368,323,579.07	574,616,268.45
392	Биет хөрөнгө	366,921,287.54	573,396,268.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	360,116,400.00	581,226,396.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-47,059,126.92	-58,098,316.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	51,762,412.60	63,107,412.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-42,483,205.51	-47,403,905.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,233,495.50	27,233,495.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,420,967.48	-23,303,516.96
39214	Бусад үндсэн хөрөнгө	87,188,253.00	87,188,253.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-47,415,973.65	-56,553,549.33
393	Биет бус хөрөнгө	1,402,291.53	1,220,000.00
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,067,708.47	-1,250,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,220,000.00	1,220,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	483,163,797.67	708,014,796.63
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,002,280.00	500,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,002,280.00	500,000.00
413	Өглөг	4,002,280.00	500,000.00
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		500,000.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,002,280.00	
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	479,161,517.67	707,514,796.63
51	Засгийн газрын хувь оролцоо	479,161,517.67	707,514,796.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	99,492,449.14	99,492,449.14
512	Хуримтлагдсан үр дүн	373,950,494.94	602,303,773.90

5121	Өмнөх үеийн үр дүн	373,950,494.94	374,002,577.96
5122	Тайлант үеийн үр дүн		228,301,195.94
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,718,573.59	5,718,573.59
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	483,163,797.67	708,014,796.63

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

<i>/төгрөгөөр/</i>			
Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	626,567,424.96	1,040,127,686.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		260,262,995.94
120	Нийтлэг татварын бус орлого		260,262,995.94
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		70,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		232,454,996.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		27,807,999.94
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	626,567,424.96	779,864,690.69
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	555,101,200.00	702,962,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	555,101,200.00	702,962,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		35,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		35,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,466,224.96	76,867,290.69
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,466,224.96	76,867,290.69
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	564,388,734.34	811,826,490.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	564,388,734.34	811,826,490.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	556,730,334.34	803,503,490.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	341,135,932.05	549,107,198.64
210101	Үндсэн цалин	262,665,566.92	320,319,530.16
210102	Нэмэгдэл	66,682,317.13	203,321,988.48
210104	Урамшуулал	11,788,048.00	25,465,680.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,153,579.71	66,053,840.72
210201	Тэтгэврийн даатгал	28,487,505.56	43,673,686.89
210202	Тэтгэмжийн даатгал	3,384,647.42	5,758,247.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,663,718.01	2,920,220.46
210204	Ажилгүйдлийн даатгал	581,485.15	2,741,795.93
210205	Эрүүл мэндийн даатгал	6,036,223.57	10,959,890.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,466,224.96	71,867,290.69
210301	Гэрэл, цахилгаан	6,348,130.78	5,920,590.69
210302	Түлш, халаалт	62,862,094.18	62,861,700.00
210303	Цэвэр, бохир ус	2,256,000.00	3,085,000.00
2105	Нормативт зардал	57,019,811.00	62,909,971.00

210502	Хоол, хүнс	57,019,811.00	62,909,971.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		5,000,000.00
210604	Урсгал засвар		5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	353,500.00	1,676,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	353,500.00	1,676,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,601,286.62	46,888,389.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,287,140.00	15,375,990.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,178,200.00	5,298,010.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	27,135,946.62	26,214,389.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,658,400.00	8,323,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,658,400.00	8,323,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,658,400.00	8,323,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	62,178,690.62	228,301,195.94
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	62,178,690.62	228,301,195.94

2.3 Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	626,567,424.96	779,864,690.69
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	626,567,424.96	779,864,690.69
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	555,101,200.00	702,962,400.00
1E+05	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	555,101,200.00	702,962,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		35,000.00
1E+05	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		35,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,466,224.96	76,867,290.69
1E+05	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,466,224.96	76,867,290.69
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	539,763,276.72	793,742,210.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	539,763,276.72	793,742,210.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	532,104,876.72	785,419,210.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,664,614.91	548,607,198.64
2E+05	Үндсэн цалин	241,191,969.00	376,448,720.87
2E+05	Нэмэгдэл	89,908,658.91	146,755,879.59
2E+05	Урамшуулал	11,563,987.00	25,402,598.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,624,896.85	66,053,840.72
2E+05	Тэтгэврийн даатгал	27,391,951.74	47,128,153.80
2E+05	Тэтгэмжийн даатгал	3,183,303.87	4,566,701.26
2E+05	ҮОМШӨ-ний даатгал	2,533,583.17	2,283,399.53
2E+05	Ажилгүйдлийн даатгал	581,453.46	2,283,400.53

2E+05	Эрүүл мэндийн даатгал	5,934,604.61	9,792,185.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,466,224.96	71,867,290.69
2E+05	Гэрэл, цахилгаан	6,348,130.78	5,920,590.69
2E+05	Түлш, халаалт	62,862,094.18	62,861,700.00
2E+05	Цэвэр, бохир ус	2,256,000.00	3,085,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	55,173,300.00	65,018,780.00
2E+05	Хоол, хүнс	55,173,300.00	65,018,780.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		5,000,000.00
2E+05	Урсгал засвар		5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	785,500.00	1,676,800.00
2E+05	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	785,500.00	1,676,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,390,340.00	27,195,300.00
2E+05	Бараа үйлчилгээний бусад зардал	20,033,940.00	21,646,600.00
2E+05	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,356,400.00	5,548,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,658,400.00	8,323,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,658,400.00	8,323,000.00
2E+05	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,658,400.00	8,323,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	86,804,148.24	-13,877,519.36
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	86,804,148.24	-13,877,519.36
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		93,363,868.60
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		79,486,349.24

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	99,492,449.14	5,718,573.59	373,950,494.94	479,161,517.67
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			52,083.02	52,083.02
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Тайлант үеийн үр дүн			228,301,195.94	228,301,195.94
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	99,492,449.14	5,718,573.59	602,303,773.90	707,514,796.63

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	874,647,300.00	793,742,210.05	80,905,089.95	90.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	874,647,300.00	793,742,210.05	80,905,089.95	90.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	866,324,300.00	785,419,210.05	80,905,089.95	90.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	616,218,900.00	548,607,198.64	67,611,701.36	89.0
2E+05	Үндсэн цалин	421,682,600.00	376,448,720.87	45,233,879.13	89.3
2E+05	Нэмэгдэл	175,177,200.00	146,755,879.59	28,421,320.41	83.8
2E+05	Урамшуулал	19,359,100.00	25,402,598.18	-6,043,498.18	131.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,771,100.00	66,053,840.72	6,717,259.28	90.8
2E+05	Тэтгэврийн даатгал	49,485,500.00	47,128,153.80	2,357,346.20	95.2
2E+05	Тэтгэмжийн даатгал	5,820,600.00	4,566,701.26	1,253,898.74	78.5
2E+05	ҮОМШӨ-ний даатгал	2,910,800.00	2,283,399.53	627,400.47	78.5
2E+05	Ажилгүйдлийн даатгал	2,910,800.00	2,283,400.53	627,399.47	78.5
2E+05	Эрүүл мэндийн даатгал	11,643,400.00	9,792,185.60	1,851,214.40	84.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,253,700.00	71,867,290.69	1,386,409.31	98.1
2E+05	Гэрэл, цахилгаан	7,307,000.00	5,920,590.69	1,386,409.31	81.0
2E+05	Түлш, халаалт	62,861,700.00	62,861,700.00		100.0
2E+05	Цэвэр, бохир ус	3,085,000.00	3,085,000.00		100.0
2104	Хангамж, бараа материалын зардал				
2105	Нормативт зардал	67,733,700.00	65,018,780.00	2,714,920.00	96.0
2E+05	Хоол, хүнс	67,733,700.00	65,018,780.00	2,714,920.00	96.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00		100.0
2E+05	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,676,800.00	1,676,800.00		100.0
2E+05	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,676,800.00	1,676,800.00		100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,670,100.00	27,195,300.00	2,474,800.00	91.7
2E+05	Бараа үйлчилгээний бусад зардал	24,121,400.00	21,646,600.00	2,474,800.00	89.7
2E+05	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,548,700.00	5,548,700.00		100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,323,000.00	8,323,000.00		100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,323,000.00	8,323,000.00		100.0
2E+05	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,323,000.00	8,323,000.00		100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	874,647,300.00	779,864,690.69	94,782,609.31	89.2
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	796,393,600.00	702,997,400.00	93,396,200.00	88.3
1E+05	Улсын төсвөөс санхүүжих	796,393,600.00	702,962,400.00	93,431,200.00	88.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		35,000.00	-35,000.00	
1E+05	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		35,000.00	-35,000.00	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	78,253,700.00	76,867,290.69	1,386,409.31	98.2

1E+05	Орон нутгийн төсвөөс	78,253,700.00	76,867,290.69	1,386,409.31	98.2
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		-70,000.00	70,000.00	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		93,363,868.60	93,363,868.60	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		79,486,349.24	79,486,349.24	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Хамтын оролцоог идэвхжүүлж, үнэлгээний үр дүнд суурилан хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжин сургалтын чанарт ахиц гаргах зорилгыг дэвшүүлж байна.” гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Малчдын болон алслагдсан бүс нутагт амьдарч байгаа өрхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг хувилбарт сургалт, үйл ажиллагаагаар дэмжих, 5 настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулан сургуульд элсэн суралцах бэлтгэл хангах;
- Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх, сурлагын амжилтад ахиц гаргах;
- Цэцэрлэгт суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, багшийн мэргэжлийн хөгжлийн цахим системийг ашиглан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц үр дүнг тооцох;
- Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах, тэгш боломж олгох орчныг бүрдүүлж, тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх;
- Онцгой байдлын үед суралцагч өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлэх дадлага, сургуулилтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, аливаа гамшгийн эрсдэлийг даван туулах чадварыг хөгжүүлэх;
- Цэцэрлэгийн номын сангийн үйлчилгээг идэвхжүүлж, хүүхдийн сурч хөгжих, төлөвших, хамтран ажиллах, мэдээлэл авахад нь туслах, үйлчилгээний нээлттэй байдлыг хангах;

3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;

- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жавхланта сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 224,851.0 мянган төгрөгөөр буюу 31.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	93,363.9	79,486.3	(13,877.5)
Авлага	-	-	-
Бараа материал	21,476.4	53,912.2	32,435.8
Үндсэн хөрөнгө	368,323.6	574,616.3	206,292.7
Нийт хөрөнгө	483,163.8	708,014.8	224,851.0
Өглөг	4,002.3	500.0	(3,502.3)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	479,161.5	707,514.8	228,353.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	483,163.8	708,014.8	224,851.0

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 79,486.3 мянган төгрөг болж 13,877.5 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн зарцуулалттай холбоотой
- Бараа материал дансны үлдэгдэл 53,912.2 мянган төгрөг болж 32,435.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 82,736.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, БЕГ-аас 17,600.0 мянган төгрөгийн тоглоом наадгай, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 10,208.0 мянган төгрөгийн зөөлөн эдлэл үнэ төлбөргүй авч, 78,109.1 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулснаас,

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 761,225.5 мянган төгрөг болж 232,454.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь сумын ОНХС-ийн хөрөнгөөр цэцэрлэгийн барилгын их завсар хийж 221,109.9 мянган төгрөгөөр капиталжуулсан, Боловсролын газраас 9,745.0 мянган төгрөгийн, эцэг эхчүүдээс 1,600.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй орлогоор хүлээн авснаас шалтгаалсан байна.

3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 558,963.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 88,507.6 мянган төгрөг, нийт 647,471.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин хөлс, НДШ-ийн зардлыг 9,767.1 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 5,253.9 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 23,965.5 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 10,000.0 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн зардлыг мэдээлэл технологийн зардлыг 802.1 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 31,624.0 мянган төгрөгөөр, нийт 81,412.6 мянган төгрөгөөр бууруулж, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,664.6 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн зардлыг 3,142.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийг 573,865.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайланд онд төсөвт 7 удаа зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 796,393.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 78,253.7 мянган төгрөгийн нийт **874,647.3** мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, НДШ-ийн зардлыг 253,278.0 мянган төгрөгөөр,
- Хоолны зардлыг 23,186.3 мянган төгрөгөөр;
- Урсгал засварын зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 1,676.8 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 9,317.4 мянган төгрөгөөр,
- Урсгал шилжүүлгийн зардлыг 8,323.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн гэх мэт

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 874,647.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 793,742.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 793,742.2 мянган төгрөг буюу 90.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 80,905.1 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1	80233-Хүүхэд хамгаалал	710.4	710.4	-	100.0
		2	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,280.5	1,280.5	-	100.0
		3	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	65,431.9	62,717.0	2,714.9	95.9
		4	81816Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,276.6	2,276.6	-	100.0
		5	81823-Боловсролын байгууллагын багш	1,280.5	500.0	780.5	39.0
		6	81823-Нүүдлийн бүлэгт хамруулах	27,237.4	27,237.4	-	100.0
		7	81834-Боловсролын стандарт сургалт	671,381.1	595,427.8	75,953.3	88.7
		8	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	26,795.2	26,795.2	-	100.0
		9	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	-	(70.0)	70.0	
		10	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	78,253.7	76,867.3	1,386.4	98.2
Нийт				874,647.3	793,742.2	80,905.1	90.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Хүүхдийн хоол	67,733.7	67,733.7	НТШ
Нийт дүн		67,733.7	67,733.7	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалт /Анхны батлагдсан төсвөөр тендерийн үнийн саналыг өгсөн./ - ыг 2 удаа зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан “Баянжаргалан хайрхан” ХХК-тай гэрээг байгуулж худалдан авалтыг гүйцэтгэжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэгийн /цаашид Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэг гэх/ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 564,388.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,643.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,

- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит” ХХК нь 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 912 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг тус байгууллагад хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон худалдан авах ажиллагаатай холбоотой 2 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлжээ.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	4,002.3	1	4,002.3	100.0
Зөвлөмж	2		2		100.0
Нийт дүн	3	4,002.3	2	4,002.3	100.0

4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа илрээгүй байна.

Аудитаар нийт 12,254.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 11,754.4 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 1 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Албан шаардлага

1.Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 500.0 мянган төгрөгийн цалингийн өглөг үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үнэ төлбөргүй хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн 11,754.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна..

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өглөг үүсгэсэн	1	500.0			1	500.0						
Үнэ төлбөргүй хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	1	11,754.4					1	11,754.4				
Дүн	2	12,254.4			1	500.0	1	11,754.4				



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 72/А.1850385

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 500.0 мянган төгрөгийн цалингийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: 4.2.1.11: "Хууль тогтоомж,зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төлбөр тооцоог хянаагүйн улмаас авлага үүсгэсэн арилган давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч С.Оюунчимэг, нягтлан бодогч Б.Эрдэнэцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.НАРАНЧИМЭГ

432504215

АЛБАН ШААРДЛАГА, ТӨЛБӨРИЙН АКТЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХУУДАС

А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1. Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Сэлэнгэ аймаг Жавхланта сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	СЭА-2025/142/НА-СТА-ТШЗ
-----------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------------	-------------------------

1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит
---------------------------	----------------------------------------------------------------------	-------------------	-----------------------------

1.5 Албан шаардлага / төлбөрийн актын дугаар	СЭА-2025/142/НА-СТА-ТШЗ	1.6 Огноо	2025.02.24	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	500,000.00
----------------------------------------------	-------------------------	-----------	------------	----------------------------	------------

1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл	Алдаа зөрчлийн товч утга	Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 500.0 мянган төгрөгийн цалингийн авлага үүсгэсэн байна.			
	Алдаа зөрчлийн ангилал	Хууль, тогтоомж зөрчсөн			
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оролдох)	4.2.1.11: "Хууль тогтоомж,зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал			
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Төсвийн тухай хууль		
		Заалт	6.4.8		
Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаал			
	Заалт	4.2.1.9, 4.2.1.11			

1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд	1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд	
	Тухайн байгууллагын дансанд	

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Бараа материалын тайлан		2024 он	
2	Харилцахын баримт		2024 он	

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

№	Аудитын багийн		Хариуцагч			
	Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	Б.Наранчимэг	Аудитор	Жавхланта 1 дүгээр цэцэрлэг	Эрхлэгч	С.Оюунчимэг	99593138
				Нягтлан бодогч	Б.Эрдэнэцэцэг	99253361

4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор	2/25	-	
2	Аудитын менежер	21/25	-	

4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
---	--------------	----------	-------	------------

1	Тэргүүлэх аудитор	Ч.Энхтуяа	4/25	
2				

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг		Гарын үсэг
1	Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын	Огноо		
		Дугаар		
2	Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
3	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн	Огноо		2025.02.24
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
4	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан	Байгууллагын нэр		Жавхлант 1 дүгээр цэцэрлэг
		Ажилтны	Овог нэр	Б.Эрдэнэцэцэг
			Албан тушаал	Нягтлан бодогч
5	Албан шаардлага, төлбөрийн актыг хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр		Пийк Ом Аудит ХХК
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо		